




Мэдээлэлзүй

*“MS EXCEL ПРОГРАМД
ХЯЛБАР ТОМЪЁО, ФУНКЦ
ОРУУЛАХ” СУДАЛГААТ
ХИЧЭЭЛИЙН АРГА ЗҮЙН
ТУРШЛАГА*

СУДАЛГААТ ХИЧЭЭЛИЙГ ЯВУУЛСАН ҮНДЭСЛЭЛ:

“Багшлахуйн аргазүйн хөгжлийг түгээн дэлгэрүүлэх тогтолцоог бэхжүүлэх нь” төслийн сургалтанд хамрагдсаны дараа өөрийнхүд дээр хичээлийн судалгааны арга зүйг эзэмшүүлэх сургалтыг зохион байгуулах хэрэгцээ шаардлага гарсан. Иймд сургалтыг мэдээлэлзүйн судлагдахуунд түшиглэн явуулахаар тогтсон.

ХИЧЭЭЛИЙН САНАА:

- ❖ Энэ хичээл нь 8-р ангийн “Хүснэгтэн мэдээлэл боловсруулах програм” нэгж хичээлийн 3 дахь ээлжит хичээл юм. Энэ хичээлийн гол санаа нь сурагчдаар MS Excel програмыг ашиглан хялбар тооцоо хийх аргыг олуулж, түүнийг өөрсдийн амьдрал ахуйдаа хэрэглэх чадварыг эзэмшүүлэхийг зорьсон.
- ❖ Хичээлийн бэлтгэл судалгааг Баянтэс сумын бүрэн дунд сургуулийн мэдээлэлзүйн судлагдахууны багийн гишүүд хамтран хийсэн.
- ❖ 2012 оны 4 сард 8-р ангид 2 удаа, 2013 оны 4-р сард 8а,б ангид 2 удаа нийт 4 удаа зааж хэлэлцүүлэг хийх замаар хөтөлбөрөө сайжруулсан.



Хичээлийн тухай

Энэ хичээлийн сэдэлжүүлэх хэсэгт сампин, тооны машин ашиглаж тоог бодоход аль хэрэгсэл нь хурдан байгааг баг бүрээр гаргуулах байсан боловч багийн гишүүн бүр харилцан адилгүй бодож байснаас хугацаа их орсон учир сайн чадна гэсэн 2 сурагчийг гарган ирж бодуулсан.

Мөн мэдлэг бүтээх хэсэгт зөвлөмжүүдээ бичвэр хэлбэрээр өгсөн нь сурагчид сайн уншихгүй сул тал байсан тул зөвлөмжөө бичвэр болон видео хэлбэрээр өгч сайжруулсан.

Бататгах хэсэгт сурагчид өөрсдийн орлого зарлагаа бодох байсан. Ямар загвараар хийхээ мэдэхгүй эргэлзэж хугацаа их орсон тул өмнөх хичээлд нь орлого зарлагын хүснэгттэй төстэй хүснэгтүүдийг хийлгэн хэлбэржүүлснээр ажиллахад хялбар болж хичээлийн хөтөлбөр сайжирсан.



Хичээлийн эхлэл хэсэг

Хичээл эхлэхийн өмнө сурагчид хоёр хоёроороо баг болон суудлын хуваарийн /[хавсралт8](#)/ дагуу суудлаа эзэлсэн. Энэ ангийн сурагчид өмнөх хичээлээр MS excel програм дээрээ мэдээлэл оруулж хэлбэржүүлж, хуулах, зөөх үйлдлүүдийг хийх чадварыг олж авсан байснаар багшийн бэлтгэсэн “Хичээл3” /[хавсралт7](#)/ нэртэй файльтай ажилласан. Энэ файльтай ажилснаар програм дээрээ нэмэх, хасах, үржих, хуваах гэх мэт үйлдэл бүхий томъёо оруулах, олон тооны нийлбэр олох функц ашиглах, хялбар тооцоо хийх чадваруудыг эзэмших зорилготой юм.



Хичээлийн эхлэл хэсэг

- Хичээлийн эхэнд багш сурагчдаар тооцоо хийх боломжтой хэрэгслүүдийг нэрлүүлсэн. Сурагчид тооны машин, гар утас, сампин, компьютер, дэвтэр бал гэх мэт олон хариултуудыг өгсөн. Хариултан дээр нь тулгуурлан өгөгдсөн тоог бодох даалгавар өгсөн. Хүүхэд бүр дэвтэр дээрээ, 2 сурагч гарч ирэн сампин, тооны машин ашиглан бодож зөв хариултаа картаар/хавс4а/ өргөсөн. Сурагчдаас аль хэрэгсэлээр бодох нь хурдан байгааг асуухад тооны машин гэсэн хариултыг өгсөн. Багш цааш нь дүү сурагчдаас ирсэн олон ижил үйлдлүүдийг хийх, олон тоог нэмэх үйлдэл бүхий хүсэлтийг/хавс4в/ сурагчдад танилцуулсан. Сурагчид тооны машинаар бодож үйлдлүүдийг гүйцэтгэж байхад хугацаа их орох, өмнөх хариугаа тэмдэглэх зэрэг асуудлууд тулгарсан учир багш сурагчдаас “ Үүнийг хялбараар, хурдан бодох ямар арга байгаа бол?” гэсэн асуулт тавьсан. Сурагчид тийм аргыг өнөөдрийн хичээлээрээ хайхыг хүсэж хичээлийн зорилго, зорилттой танилцан, дэвтэртээ тэмдэглэн авсан. Хичээлийн эхэнд ашигласан зөв хариулт бүхий картны ард байгаа зааврийн/хавс4б/ дагуу олон тоог хялбараар бодох арга хайхаар дараагийн алхамдаа орсон.



Хичээлийн мэдлэг бүтээлгэх өрнөл хэсэг

- Сурагчид “Хичээл3” нэртэй файлыг нээж өөрийн нэрээ бичиж дараагийн алхамд шилжсэн. Энэ файлд дүү сурагчдаас ирсэн хүсэлт дээрхи тоог бодох даалгаварууд бичигдсэн байгааг сурагчдаар ажиглуулахад сурагчид хялбархан олж байсан. Даалгавар 1,2,3-ыг гүйцэтгэснээр програм дээрээ нэмэх, хасах, үржих, хуваах үйлдэл бүхий томъёо оруулж сурах, мөн оруулсан томъёогоо хуулах үйлдлүүдийг хийсэн. Энэ үйл ажиллагааг хийж байхад зөв буруу хийж байгаа нь сурагчдад мэдээлэлгдэж байхаар, бас зөвлөмжөө унших боломжыг хангасан байхаар файлаа бэлтгэсэн.
- Эдгээр даалгаваруудыг гүйцтгэж байхад сурагчид томъёог оруулахдаа нүдний хаяг ашиглахгүй шууд гараас өгөх, оруулсан томъёогоо хуулах үйлдэл хийхгүй ахин томъёо бичих зэрэг алдаа гаргасан. Энэ үед багш “Зөвлөмжөө сайн хараарай. Өмнөх мэдлэгээ ашиглан ажлаа хөнгөвчлөөрөй” гэх мэтээр сурагчдаа чиглүүлж байсан. Даалгавар 4-т олон тоог нэмэх функц ашиглаж сурсан.
- Түрүүлж дууссан сурагчид бусад багийнхандаа туслалцаа үзүүлсэн. Даалгавар 1-4-ийг хийж дуусаад сурагчид хариунуудаа хүсэлт дээрээ бичиж дүү нартаа өгөхөд бэлэн болгосон. Сурагчдын олж авсан шинэ мэдлэгийг багш нэгтгэн ярилцаж самбарт тэмдэглэл хийн сурагчдыг дэвтэртээ тэмдэглэхийг санал болгосон.



- Эдгээр ажлуудын дараа сурагчид олж авсан чадвараа ашиглан өөрийн нэг сарын орлого зарлагаа тооцоолох даалгаварыг гүйцэтгэсэн. Зөвхөн нэг сард хэрэглэдэг хичээлийн хэрэглэл, өдөр тутамын хэрэглээний мөнгөнийхөө тооцоог хийцгээе” гэж санал болгосон. Сурагчдын хийсэн тооцооны үр дүн нь харилцан адилгүй, зарим баг нь 20000 хүрэхгүй байхад, зарим нь илүү гарсан.
- Эдгээр даалгаварыг гүйцэтгэж байхад багш сурагчдийн олж авсан чадваруудыг тэмдэглэн чадварын хүснэгтийг/[хавс6/](#) хөтөлсөн.



Хичээлийн төгсгөл хэсгийн шийдэл

- Мэдлэгээ шалгая хэсэгт шилжин 5 даалгавар гүйцэтгээд өнөөдрийн хичээлээр сурсан зүйлээ бататган үнэлгээ авсан. Сурагчдийн даалгавар гүйцэтгэсэн байдлаас хамаарч үнэлгээ нь графикаар гарч ирсэн. Хичээлийн төгсгөлд олж авсан мэдлэгүүдээ нэгтгэн харилцан ярилцаж тэмдэглэл хөтөлсөн. Гэрийн даалгаварт 1-рт нь “Гэр бүлийнхээ нэг сарын орлого зарлагыг тооцож ирээрэй” гэсэн даалгавар өгсөн. Энэ нь өнөөдөр сурсан зүйлээ хэрэглэх дадлага болох юм.

2-рт нь “Цахим хүснэгт, цаасан дээр зурсан хүснэгтээс ямар ялгаатай вэ?” гэсэн асуулт тавсан. Энэ нь дараагийн хичээлийн сэдэлжүүлэх аргын нэг хэсэг юм. Сурагчид гэрийн даалгавараа тэмдэглэж авч чадаагүй тул компьютерийн гар доогуур байсан ТӨМ2/хавс4г/-ийг дэвтэрт нь наалгуулснаар энэ удаагийн хичээл дууссан.



Дүгнэлт:

- Энэ хичээлийн гол онцлог нь сурагчид эрэл хайгуул хийх замаар мэдлэгээ бүтээж, түүнийгээ амьдрал ахуйдаа хэрэглэх, ашиглаж сурах явдал юм. Мөн MS Excel програм тооцоо хийхэд хялбар, цаг хугацаа хэмнэх давуу талтай гэдгийг сурагчид ойлгосон.
- Хичээлийн эхнээс л сурагчдад асуудал тулгаруулахыг зорьсон. Дүү сурагчдаас хүсэлт/хавс4в/ ирүүлж түүнд нь хариулуулсан нь дүү нартаа тусалж байна гэсэн сэтгэгдэлийг сурагчдад төрүүлэх.
- Даалгаваруудыг файл хэлбэрээр өгсөн нь цаг хугацаа хэмнэх, файлынхаа sheet бүрийг хооронд нь шилжихээр холбож сурагчдын сонирхолыг татахаар хийсэн. Зөвлөмжөө видео хэлбэрээр өгсөн нь сурагчид ашиглахад хялбар, ойлгомжтой байсан.
- Мэдээлэлзүйн хичээл дээр бүхий л зүйл слайдаар үзүүлээд өнгөрдөг. Тиймээс самбар дээр гол ойлголтуудаа үлдээж самбараа зөв ашиглахыг зорьсон нь оновчтой болсон. Самбар төлөвлөлтийг /хавс5/ сайн хийх хэрэгтэй байдаг.
- Хичээлийн төгсгөлд сурагчдийн үнэлгээ нь өөрсдөд нь графикаар харагдаж байгаа нь хүүхдүүдэд сонирхолтой байсан. Мөн багш хичээлийн турш сурагчид ямар чадвар олж авч байгааг нь чадварын хүснэгтэнд/хавс6/ тэмдэглэж байсан нь хичээлийн дараа дүгнэлт, анализ хийхэд хялбар байлаа.
- Сурагчид хичээлийн дараа өөрийн үнэлгээг багшид өгсөн. Энэ нь нэгж хичээлийн төгсгөлд багшийн үнэлгээ, сурагчийн өөрийн үнэлгээ/хавс4д/, стандарт үнэлгээ 3-г харьцуулан дүгнэлт хийхэд зориулагдсан.



Хавсралт

- Нэгж хичээлийн хөтөлбөр
- Ээлжит хичээлийн хөтөлбөр №3
- Ээлжит хичээлийн Presentation
- Хичээлийн хэрэглэгдэхүүнүүд
/ а.Карт, б.Заавар, в.Хүсэлт, г.ТӨМ2, д.Сурагчийн
өөрийн үнэлгээ/
- Самбар төтөвлөлт
- Чадварын хүснэгт
- “Хичээл3” нэртэй файл
- Суудлын хуваарь
- Хичээлийн хэлэлцүүлэгийн тэмдэглэл хөтлөх
хуудас
- Судалгаат хичээлийн зурагнууд





Хичээлдээ идэвхтэй
оролцсон сурагчдадаа
баярлалаа.